



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/159

Булган сум


**“Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл”
аян зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 15 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөр батлах тухай” Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хуралдааны IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аяныг аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Засаглалын сэргэлт” зорилттой уялдуулан орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Наранбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025. оны
03 дугаар сарын 17-ны/ний өдрийн А/159 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

“Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аян зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
салбар зөвлөлийн гишүүн)
- Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн)
- М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн
гишүүн)
- Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, салбар
зөвлөлийн гишүүн)
- Ч.Цогбуян (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
- Г.Ангирмаа (Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын
дарга, салбар зөвлөлийн гишүүн)
- Т.Хонгорзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны
дарга)
- Э.Хосбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний
нөөцийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Ж.Оюунгэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн Сургалт, сурталчилгаа, хүний
эрхийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Б.Энхмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Өргөдөл,
гомдол, мэдээллийн ил тод байдал, цахим үйлчилгээ
хариуцсан мэргэжилтэн)
- Б.Бат-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: Ч.Баттуяа (Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг
дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга)

03 дугаар сарын 17-ны/ний өдрийн А/СС... дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

**“ШИНЭТГЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ”
АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	2	3	4
Төрийн албаны хууль тогтоомжийг сурталчлан таниулах, төрийн албан хаагч, иргэдийг мэдээллээр хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хүрээнд:			
1	“Монгол Улсын Төрийн албаны шинэчлэл, үе шат сургамж” сэдэвт контент бэлтгэж, сурталчлах	2025.03 сар	Т.Хонгорзул
2	“Монгол Улсын Төрийн албаны шинэчлэл, үе шат сургамж” 3 үеийн төрийн албан хаагчдын хэлэлцүүлэг зохион байгуулах	2025.03 сар	Д.Эрдэнэбилэг
3	“Ахмад ажилтны зөвлөх үйлчилгээ”-г агентлаг, байгууллага, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт хэрэгжүүлэх	2025.03-05 сар	М.Батчимэг
4	Аяны хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим албан ёсны цахим хуудас, Булган аймгийн албан ёсны цахим хуудас болон бусад мэдээллийн эх сурвалжаар түгээн сурталчлах	2025.03-06 сар	Ч.Баттуяа Т.Хонгорзул
5	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 3 контент бэлтгэн түгээх	2025.03-05 сар	Б.Одхүү Г.Ангирмаа Ж.Оюунгэрэл
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, зөрчилгүй ажиллахыг соёлыг хэвшүүлж, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалт зохион байгуулах	2025.03-05 сар	Д.Эрдэнэбилэг Ч.Баттуяа
Төрийн албаны Салбар зөвлөл, төрийн байгууллага, албан хаагчдын сайн туршлага болон төрийн албанд ажиллахын давуу тал, соёл, инновацыг танилцуулах, сурталчлах хүрээнд:			
7	Хүний нөөцийн чиглэлээр ажиллаж буй албан хаагчдыг хөгжүүлэх “Булган-HR” клубийг үүсгэн байгуулж	2025.03 сар	Д.Эрдэнэбилэг Э.Хосбаяр
8	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чадваржуулах, дадлагажуулах хөтөлбөр хэрэгжүүлэх	2025.02-06 сар	Д.Эрдэнэбилэг Э.Хосбаяр
9	Төрийн албан хаагчдыг төрийн албанд ажиллахын давуу талыг илэрхийлсэн 5-аас дээш контент бэлтгэж, түгээн бусдад нэвтрүүлэх	2025.02-06 сар	Ч.Баттуяа Т.Хонгорзул
10	Шилдэг төрийн албан хаагчдын бүтээлч ажил, үр дүнг тасралтгүй сурталчлах	2025.02-06 сар	Ч.Баттуяа Т.Хонгорзул Э.Хосбаяр
11	Төрийн албан хаагчдын харилцааны ур чадварыг үнэлэх, судалгаа авах	2025.03 сар	Ч.Цогбуян Б.Бат-Эрдэнэ
12	Төрийн албан хаагчдын илтгэх, харилцааны ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	2025.03, 05 сар	Д.Эрдэнэбилэг Ч.Цогбуян Э.Хосбаяр
13	Төрийн албан хаагчдад судалгааны арга зүй эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	2025.03 сар	Д.Эрдэнэбилэг Ч.Баттуяа Б.Бат-Эрдэнэ

14	Төрийн албан хаагчдын баримт бичиг боловсруулах ур чадварыг үнэлж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	2025.02-06 сар	Д.Эрдэнэбилэг Б.Одхүү
15	Төрийн албан хаагчдын цахим хэрэглээний ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах	2025.03, 05 сар	Д.Эрдэнэбилэг Б.Энхмаа
16	Салбар, орон нутгийн төрийн байгууллагын сайн соёл, инновацыг дэмжин "Nudge" буюу эерэг түлхцийн аргыг ашиглан нэвтрүүлж, постероор "Инновац од", "Хамтдаа нэг алхам урагш" зэрэг уриан дор сурталчлан таниулах, түгээх	2025.02-06 сар	Ч.Баттуяа Т.Хонгорзул Э.Хосбаяр
"Бид иргэдээ сонсож шийднэ" иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх өдөртэй болох, бусад ажлын хүрээнд:			
17	"Бид иргэдээ сонсож шийднэ" өдрийг сар бүр зохион байгуулж, хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг хэвшүүлэх	2025.03-06 сар	Д.Наранбаяр Д.Эрдэнэбилэг
18	Иргэдээс 3-аас дээш сувгаар иргэдээс санал, өргөдөл хүлээн авч шийдвэрлэх	2025.03-06 сар	Ч.Баттуяа
19	"Бид иргэдээ сонсож шийднэ" постер бэлтгэж, салбар зөвлөл, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулж, иргэдэд хүргэх	2025.03 сар	Ч.Баттуяа Т.Хонгорзул
20	Иргэдээс харьяалах төрийн үйлчилгээний чиглэлээр судалгаа авч, хэрэгжүүлбэл зохих тулгамдаж буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, шинэлэг бүтээлч шийдлээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2025.03-06 сар	Ч.Цогбуян Б.Бат-Эрдэнэ
21	Төрийн албаны нөөцөд байгаа иргэн болон оюутан, ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад Монголын төрт ёсны түүхэн уламжлал, төрийн албаны онцлог, бахархал, төрийн албанд ажиллахын давуу талыг сурталчилсан арга хэмжээг 5-аас доошгүй удаа зохион байгуулах	2025.03-06 сар	Д.Эрдэнэбилэг